



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/505

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог  
хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах,  
тээвэрлэх, боловсруулах, устгах заавар  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Хог хаягдлын тухай хуулийн 8.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, зааврыг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хадгалах зааврыг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх зааврыг гуравдугаар, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах зааврыг дөрөвдүгээр, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламжид тавигдах шаардлагыг тавдугаар, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, тавигдах шаардлагыг зургаадугаар, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийн сургалтад тавигдах ерөнхий шаардлагыг долоодугаар, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг бүртгэх маягтыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвтөө тусгахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-д даалгасугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158, 179, 380 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 02 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ


Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## Нэг. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах заавар

### 1.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал

Эрүүл мэндийн байгууллагаас үүсч буй нийт хог хаягдлыг энгийн болон аюултай гэж 2 ангилна. Энгийн хог хаягдлыг дотор нь ахуйн ба дахивар нөөц гэж ангилна. Аюултай хог хаягдлыг дотор нь халдвартай, хурц иртэй, эмгэг, эмийн болон эсэд хортой нөлөөтэй, химийн бодисын болон цацраг идэвхт хог хаягдал гэж 6 ангилна.

#### Бүдүүвч 1: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал



### 1.2. Энгийн хог хаягдал

Энгийн хог хаягдалд эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуур, эм, урвалжийн гадна талын сав баглаа боодол, нэг удаагийн зүүний

хуванцар таглаа (бохирлогдоогүй) хоол хүнсний үлдэгдэл зэрэг хаягдуудаас гадна шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг ашиглаж болох дахивар нөөц хамаарна (Хүснэгт 1).

### Хүснэгт 1: Энгийн хог хаягдал

Өнгө		ХАР	
Савалт		Хар өнгийн нийлэг уутанд хийнэ.	
Таних тэмдэг	Энгийн хог хаягдал	Тэмдэглэгээ, таних тэмдэг шаардлагагүй.	
	Дахивар нөөц		Цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын олон улсын таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.
Хаяглалт		Шаардлагагүй	

### 1.3. Аюултай хог хаягдал

#### 1.3.1. Халдвартай хог хаягдал

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад биологийн шингэнээр (биений өтгөн, шингэн ялгадас, цэр, шүлс, цус) бохирлогдсон зүйлс, цус, цусан бүтээгдэхүүн болон лабораторид үүсэх хүн, амьтанд халдварт дамжуулах эрсдэл бүхий эмгэг төрөгчөөр бохирлогдсон өсгөвөр, тэжээлт орчин, тэдгээрийг хэрэглэхэд ашиглагдаж буй багаж хэрэгсэл, вакцин, биобэлдмэл, судалгаа шинжилгээнд ашигласан туршилтын мал, амьтны сэг зэм гэх мэт хог хаягдал хамаарна.

### Хүснэгт 2: Халдвартай хог хаягдал

Таних тэмдэг	“Биоаюултай” таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.	
Цуглуулах	<ul style="list-style-type: none"> <li>Шингэн нэвчдэггүй, бат бөх шар өнгийн уутанд хийнэ.</li> </ul>	
Хаяглалт	<p>Хог хаягдлын уутан дээр</p> <ul style="list-style-type: none"> <li>Тасаг, нэгжийн нэр</li> <li>Уут ашиглаж эхэлсэн цаг, огноог тэмдэглэж хаягласны дараа ашиглана.</li> </ul>	

<b>Боловсруулалт, устгал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Биоаюулгүй ажиллагааны 2-4-р зэрэглэлийн лабораториос үүсэх амьд үүсгэгч агуулсан өсгөвөр, тэжээлт орчин, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдаг халдварт өвчний үед үүссэн хог хаягдлыг үүссэн цэгт нь автоклавт халдвартгүйжүүлсний дараа хог хаягдлыг түр хадгалах байр руу шилжүүлнэ.</li> <li>Идэвхтэй хэлбэрийн сурьеэтэй өвчтний цэрнээс бусад цус, цусан бүтээгдэхүүн, шээс, өтгөн гэх мэт биологийн шингэн хог хаягдлыг урьдчилан халдвартгүйжүүлэхгүйгээр бохирын шугам буюу шаардлага хангасан бохирын цооногт хийнэ.</li> <li>Идэвхтэй хэлбэрийн сурьеэтэй өвчтний цэрийг тусад нь шаардлага хангасан саванд цуглувулж, халдвартгүйжүүлсний дараа халдвартай хог хаягдлын адил устгана.</li> <li>Цус, цусан бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн байгууллагын түр хадгалах байранд халдвартгүйжүүлсний дараа хог хаягдлын цэгт устгана. Харин хог хаягдлыг тээвэрлэх, боловсруулах, устгах нэгдсэн байгууламж бүхий газарт урьдчилан халдвартгүйжүүлэлт хийхгүй.</li> </ul>
------------------------------	---

### 1.3.2. Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

Халдвартай эсэхээс үл хамааран хатгах, зүсэх гэмтэл учруулах эрсдэлтэй бүх төрлийн зүү, тариур, өндөг цоологч, наалдацын шил, мэс заслын хутга, ир, хагарсан ампул, түүнтэй адилтгах шилэн эд зүйл, пипетка, хуруу шил гэх мэт бүх төрлийн хог хаягдал хамаарна.

#### Хүснэгт 3: Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

<b>Таних тэмдэг</b>	<p>“ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО” гэсэн анхааруулга бүхий хэвтээ шугам аюулгүйн хайрцагны гадна талын 3/4 хэсэгт хэвлэгдсэн байх шаардлагатай.</p>	
<b>Цуглувулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>Шингэн нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зориулалтын зузаан цаасан болон хуванцар хайрцагт цуглувулна.</li> <li>Аюулгүйн хайрцгийг суллаж, давтан хэрэглэхийг хориглоно.</li> <li>Аюулгүйн хайрцгийг ашиглах явцад хог хаягдлыг хийхээс бусад тохиолдолд тагийг байнга хаалттай байлгана.</li> <li>Тариурын зүүний тагийг эргүүлэн таглахгүй, тариураас зүүг салгалгүйгээр тэр даруйд нь аюулгүй хайрцагт хийнэ.</li> <li>Зүү мултлагчтай хуванцар эдээр хийсэн аюулгүй хайрцаг эсвэл зүү тайрагч, шатаагч хэрэглэсэн тохиолдолд тариурын ар талын хуванцар хэсгийг шар өнгийн</li> </ul>	

	<p>халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>Аюулгүйн хайрцгийг <math>\frac{3}{4}</math> хэсгийг дүүрмэгц битүүмжилж, түр хадгалах цэг, байр руу зөөвөрлөнө. Аюулгүйн хайрцгийг 1 сараас илүү хугацаагаар ашиглаж болохгүй.</li> <li>Аюулгүйн хайрцгийг түр хадгалах байр луу зөөвөрлөх хүртэл тасаг нэгж дотор түр хадгалах шаардлагатай бол “Биоаюултай” таних тэмдэг бүхий таглаатай саванд хийж, цоожтой өрөө, эсвэл хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу газар, тусгай цэгт хадгална.</li> <li>Аюулгүйн хайрцгийг ил задгай орхиж болохгүй.</li> <li>Аюулгүйн хайрцгийг түр хадгалах байр хүртэл тагтай, бариултай “Биоаюултай” таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөнө.</li> <li>Аюулгүйн хайрцгийг энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөж болохгүй.</li> <li>Энэ төрлийн хог хаягдлыг шахаж, нягтуулж болохгүй.</li> </ul>
<b>Хаяглалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тасаг, нэгжийн нэр</li> </ul>
<b>Боловсруулалт, устгал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хурц иртэй, үзүүртэй хог хаягдлын автоклавт халдвартай хаягдлын дараа ландфилд булна.</li> </ul>

### 1.3.3. Эмгэг хог хаягдал

Мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас, хүн, амьтны цогцос, эдийн шинжилгээний лааны тосон цутгамаг, судалгаа шинжилгээнд ашигласан мал, амьтны сэг зэм зэрэг нь эмгэг хог хаягдалд хамаарна.

#### Хүснэгт 4: Эмгэг хог хаягдал

<b>Таних тэмдэг</b>	<ul style="list-style-type: none"> <li>“ЭМГЭГ ХОГ ХАЯГДАЛ - БОЛГООМЖТОЙ ХАРЬЦАНА УУ” гэсэн анхааруулга савны гадна талд байршуулна. Шингэн нэвчдэггүй, бат бөх шар өнгийн уут бүхий таглаатай саванд цуглуулна.</li> </ul>	
<b>Савлах, цуглуулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>Уутыг 3/4-аас дээш дүүргэхгүй.</li> <li>Уутыг суллан дахин ашиглаж болохгүй.</li> </ul>	
<b>Хаяглалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тасаг, нэгжийн нэр</li> </ul>	
<b>Хадгалах, зөөвөрлөх</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хөргүүрт бусад төрлийн хог хаягдаас тусад нь хадгална.</li> <li>Хөргүүртэй бол 72 цаг, хөргүүргүй бол 24 цагаас илүү хугацаанд хадгалж болохгүй.</li> <li>Шахаж, нягтуулж болохгүй.</li> </ul>	
<b>Боловсруулалт ба эцсийн устгал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламжинд агаарын бохирдлын хяналттай өндөр хэмийн шатаах зууханд шатааж, үнсийг ландфилд булшилна.</li> <li>Орон нутагт эхсийн нүхэнд хийнэ.</li> </ul>	

#### 1.3.4. Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг зэрэг нь эмийн хог хаягдалд, хавдрын эмчилгээний үед хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хэрэглэсэн зүү, тариур зэрэг нь эсэд хортой эмийн хог хаягдалд хамаарна.

#### Хүснэгт 5: Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Өнгө		XҮРЭН
	Эмийн хог хаягдал	Эсэд хортой хог хаягдал
Эрсдэл	Хортой	Эсэд хортой
Савлах Цуглуулах	<ul style="list-style-type: none"> <li>Шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд цуглуулна.</li> <li>Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй</li> <li>Энэ төрлийн хог хаягдлыг цуглуулах, савлах асуудлыг эмнэлгийн эмийн сан хариуцна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ус нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зориулалтын аюулгүйн хайрцагт цуглуулж, битүүмжилсний дараа шингэн нэвчдэггүй, бат бөх хүрэн өнгийн уутанд хийнэ.</li> <li>Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй</li> </ul>
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааран тохирох таних тэмдэгтэй байна.	
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> <li>Тасаг, нэгжийн нэр</li> <li>Хог хаягдал үүссэн огноо</li> <li>Хог хаягдлын хэмжээ</li> </ul>	
Хадгалах, зөөвөрлөх	<ul style="list-style-type: none"> <li>Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй</li> </ul>	
Боловсруу- лалт устгал	<ul style="list-style-type: none"> <li>Хугацаа нь дууссан, сав баглаа нь гэмтсэн бол үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, хандивлагчид эргүүлэн буцаана.</li> <li>Хоргүй эмийн бодис тухайлбал, витамин, давс, глюкозын уусмал, нүдний дусаалга гэх мэтийг бохирын шугамд асгаж болно.</li> <li>Эмийн хог хаягдлыг автоклавт халдвартгуйжүүлсний дараа тусгай ландфил /монофил/-д булшилна.</li> <li>Хортой эмийг шууд газарт булах, бохир усны шугам хоолойд хийх, тун шилийг бяцлахыг хориглоно.</li> <li>Төмөр саванд 50 хувь хуртэл хортой эмийг, 15:15:5 харьцаатайгаар цемент, шохой, усыг сайтар хольж дүүргэн савны тагийг гагнаж лацдан 7-28 өдрийн дараа газарт булж, дээрээс нь шингэн нэвчихгүй шавар давхарга хийнэ.</li> </ul>	

### 1.3.5. Химийн бодисын хог хаягдал

Химийн бодисын хог хаягдалд эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгах, халдвартгуйжүүлэх үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай химийн бодисууд, хүнд металл агуулсан хэрэгслүүд хамаарна. Үүнд:

- Лабораторийн хаягдал (урвалж оношлуур, химийн бодисын хаягдал г.м.)
- Уусгагч,
- Рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал,
- Формальдегид, этилен оксид,
- Хугацаа дууссан химийн бодисууд,
- Шингэн хий агуулж байсан сав, бортого
- Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтны аппарат
- Эмнэлгийн зарим төрлийн багаж хэрэгсэл,
- Өдрийн гэрэл, зайд зэрэг болно (Хүснэгт 6).

#### Хүснэгт 6: Химийн бодисын хог хаягдал

Өнгө	XURЭН
Эрсдэл	Химийн бодисын төрөл, шинж чанараас хамаарна
Савлах цуглуулах	<ul style="list-style-type: none"><li>• Өөр өөр төрлийн химийн бодисын хог хаягдлыг хольж болохгүй.</li><li>• Химийн бодисын үлдэгдлийг цуглуулах савны 50 хувиас илүү дүүргэж болохгүй.</li></ul>
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааруулан хортой, зэврэмтгий, исэл, шатамхай, холимог аюултай, хүрээлэн буй орчныг бохирдуулах материал, эсэд хортой г.м. тохирох таних тэмдэгтэй байна.
Хаяглалт	<ul style="list-style-type: none"><li>• Тасаг, нэгжийн нэр</li><li>• Хог хаягдал үүссэн огноо</li><li>• Хог хаягдлын хэмжээ</li><li>• Химийн бодисын төрлийг бичнэ.</li></ul>
Хадгалах, зөөвөрлөх	<ul style="list-style-type: none"><li>• Химийн бодисын төрөл, шинж чанараас хамааран хадгалах нөхцөл өөр өөр байна.</li><li>• Химийн бодисын хог хаягдал асгарч болзошгүй тул савыг шингэн цуглуулах тавиур дээр тавина.</li><li>• Хоорондоо урвалд орж болзошгүй химийн бодисын хог хаягдлыг тусад нь хадгална.</li><li>• Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай хүрэн өнгийн саванд хийнэ.</li></ul>

<b>Боловсруулалт устгал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Химийн бодисын хог хаягдлын шинж чанараас хамаарч үүссэн цэгт нь саармагжуулж, хоргуйжүүлж болно.</li> <li>Саармагжуулж, хоргуйжүүлэх боломжгүй химийн хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжид шилжүүлнэ.</li> </ul>
-----------------------------	--

### 1.3.6. Цацраг идэвхит хог хаягдал

Цацраг идэвхит хог хаягдалд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны ажлын явцад үүсэх ионжуулагч цацраг бүхий радионуклидууд агуулсан цацраг идэвхит шинж чанар бүхий хатуу, шингэн, хийн хаягдал хамаарна.

#### Хүснэгт 7: Цацраг идэвхит хог хаягдал

<b>Эрсдэл</b>	Бодисын төрөл, шинж чанараас хамаарна	
<b>Савлах цуглуулах</b>	Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан, түгжээтэй, бат бөх тугалган хамгаалалт бүхий зориулалтын саванд хийнэ. Бусад төрлийн хог хаягалтай хольж огт болохгүй.	
<b>Таних тэмдэг</b>		Олон улсын цацрагийн таних тэмдэгтэй байна.
<b>Хаяглалт</b>	<p>“Анхаар! Цацраг идэвхит хог хаягдал” гэсэн анхааруулгыг савны гадна талд байрлуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Цацраг идэвхит бодисын төрөл</li> <li>Хадгалж эхэлсэн хугацаа</li> <li>Хадгалах шаардлагатай хугацаа</li> <li>Аюулгүй ажиллагааны заавар</li> <li>Хог хаягдлын хэмжээг бичнэ.</li> </ul>	
<b>Боловсруулалт ба устгал</b>	Цацраг идэвхит хаягдлыг Монгол улсын “Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль” болон холбогдох дүрэм, зааварт заасны дагуу устгана.	

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

### Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хадгалах заавар

#### Нэг. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх, хадгалах үйл ажиллагаа

1.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх хамгийн оновчтой чиглэлийг байгууллага бүр тогтоож, төлөвлөгөөг гаргахдаа доорх нөхцлийг харгалзана. Үүнд:

- Хог хаягдлын хэмжээ, төрөл,
- Тасаг доторх цуглуулах цэгийн байршил,
- Түр хадгалах байрны багтаамж,
- Зөөвөрлөх сав, тэргэнцрийн хурэлцээ,
- Үйлчилгээний цаг, ачаалал зэрэг болно.

1.2. Хог хаягдлыг халдвартын эрсдэл өндөртэй тасаг нэгжүүдээс тухайлбал, эрчимт эмчилгээ, гемодиализ, мэс засал, төрөх тасгаас эхлэн өдөрт нэгээс доошгүй удаа цуглуулна.

1.3. Ууттай хог хаягдлыг түр хадгалах байр хүртэл тагтай, бариултай, "Биоаюултай" таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөнө.

1.4. Ууттай хог хаягдлыг ил задгай орхиж болохгүй.

1.5. Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөж болохгүй.

#### Хоёр. Хог хаягдлын уут дараахь шаардлага хангасан байна. Үүнд:

2.1. Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулаагүй нийлэг материалыар хийгдсэн байна.

2.2. Уут нь 7 микроос багагүй зузаантай байна (ISO 7765:2004).

2.3. Халдвартай, эмгэг, хурц үзүүртэй хог хаягдлын уут, сав нь шар өнгөтэй, эмийн болон эсэд нөлөөтэй, химийн, цацраг идэвхит хог хаягдлын уут хүрэн өнгөтэй байна.

2.4. Уутны гадна талд хог хаягдлын шинж чанараас хамаарч тусгайлсан "Биоаюултай" таних тэмдгүүдийг харагдахуйц өнгөөр, томоор хэвлэсэн байна.

#### Гурав. Хогийн сав, уут тогтоогч дараахь шаардлага хангасан байна. Үүнд:

3.1. Зориулалтын хогийн сав эсвэл уут тогтоогчийг ашиглана.

3.2. Хогийн сав нь шингэн нэвчихгүй, хуванцар, металл зэрэг материалыар хийгдсэн зузаан, бат бөх, таглаатай, хөлөөр дарж онгойлгодог байна. Хэрэв овор ихтэй бол дугуйтай байна.

3.3. Уут тогтоогч нь өндөр нягтралтай хуванцар материалыар хийгдсэн, таглаатай байх бөгөөд овор ихтэй бол дугуйтай байж болно.

3.4. Гарч байгаа хаягдлын хэмжээнээс хамаарч багтаамж нь 10 – 250 л байх бөгөөд 3/4-т “Анхаар! Энэ түвшнээс дээш дүүргэж болохгүй” гэсэн тэмдэглэгээ, “Биоаюлтай” таних тэмдэгтэй байна.

3.5. Хог хаягдалтай уут, савыг хог хаягдал үүсч байгаа газар байршуулж, хаягдлыг ангилан ялгах талаар заавар, санамжийг бичиж тавьсан байна.

**Дөрөв. Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх тэргэнцэр, сав нь дараахъ шаардлага хангасан байна.Үүнд:**

4.1. Халдвартай болон хурц иртэй, үзүүртэй хог хаягдлыг зөөвөрлөх сав, тэргэнцрийн гадна талд нь “Биоаюлтай” таних тэмдэгтэй байна.

4.2. Ачиж, буулгахад хялбар, хурц, ирмэг үзүүргүй, гадаргуу нь мелгөр, таглаатай, угааж, цэвэрлэх, халдвартгүйжүүлэхэд тохиромжтой материалыар хийгдсэн байна.

4.3. Ажилтны харах талбайг хязгаарлахуйц хэт өндөр биш, түрэх болон чирж явахад тохирсон дугуйтай, дугуй нь түгжигддэг байна.

4.4. Хог хаягдал тээвэрлэх тэргэнцэр, савыг өдөр бүр ажил дууссаны дараа угааж, халдвартгүйжүүлнэ.

4.5. Нөөцийн сав, тэргэнцэртэй байна.

**Тав. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг түр хадгалах байр, цэгт тавигдах шаардлага:**

5.1. Тухайн эрүүл мэндийн байгууллагад үүсч буй аюултай хог хаягдлын төрөл, хэмжээнээс хамааран түр хадгалах байр, эсвэл цэгтэй байна.

5.2. Нэг өдөрт үүсч буй аюултай хог хаягдлын нийт хэмжээ 20 килограмм орчим буюу түүнээс бага байвал түр хадгалах цэг, 20 килограммаас их байвал түр хадгалах байртай байна.

5.3. Хог хаягдлыг боловсруулах, устгах нэгдсэн байгууламж бүхий газарт хог хаягдлыг урьдчилан халдвартгүйжүүлэлт хийхгүй.

**5.4. Түр хадгалах байранд тавигдах шаардлага:**

5.4.1. Гадны хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зйтай газарт байрлаж, шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байх;

5.4.2. Шал нь ус нэврүүлэхгүй хатуу хучилттай байх;

5.4.3. Хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдвартгүйжүүлэхэд тохиромжтой байх;

5.4.4. Цахилгаан, цэвэр бохир усны төв шугамд холбогдсон байх;

5.4.5. Гар угаах, бохир сав, тэргэнцэр угаах цэвэрлэх боломжтой байх;

5.4.6. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайгаар хангагдсан байх;

5.4.7. Нарны гэрэл шууд тусахгүй, сэргүүн ( $18^{\circ}$  С хүртэл, 60%-иас ихгүй чийглэгтэй), агааржуулалт сайтай байх;

5.4.8. Эмгэг хог хаягдал нь биологийн идэвхтэй байдаг тул хадгалах хугацаа нь хөргүүртэй нөхцөлд буюу  $+3 +8^{\circ}\text{C}$ -т 7 хоног хүртэл, хөргүүргүй нөхцөлд өвлийн улиралд 72 цаг, зуны улиралд 24 цагаас хэтрэхгүй байх;

5.4.9. Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах хэсгүүдтэй байх;

5.4.10.Хог хаягдлыг жинлэх зориулалттай, 0,1-120 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй байх

5.4.11.Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын түр хадгалах байранд халдвартай хог хаягдлыг халдвартгүйжүүлэх хэсэгтэй байх.

5.4.12.Хог хаягдлыг халдвартгүйжүүлэх хэсэг нь агааржуулалтын системтэй байх;

5.4.13.Хана нь 2.0 метрээс доошгүй өндөртэй байх;

5.4.14.Шал нь бохир ус цуглуулах сувагт холбогдсон байх;

5.4.15.Халдвартгүйжүүлсэн хог хаягдлыг бутлах төхөөрөмжтэй байж болно.

### 5.5. Түр хадгалах цэгт тавигдах шаардлага

5.5.1. Гадны хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зайдай газарт байрлаж, шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байх;

5.5.2.Шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай байх;

5.5.3.Хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдвартгүйжүүлэхэд тохиромжтой байх;

5.5.4.Нарны гэрэл шууд тусахгүй, сэргүүн ( $18^{\circ}$  С хүртэл, 60%-иас ихгүй чийглэгтэй), агааржуулалт сайтай байх;

5.5.5. Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах боломжтой байх;

5.5.6.Хог хаягдлыг жинлэх зориулалттай, 0,1-120 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй байх

### Зургаа. Хаяг, таних тэмдэг


6.1.Гадна талдаа “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг түр хадгалах байр” гэсэн хаяг, дараахь таних тэмдэгтэй байна.



Түр хадгалах байранд  
гадны хүн орохыг  
хориглоно

6.2.Дотор талдаа дараахь таних тэмдэгтэй байна.

Хоол идэх, уухыг хориглоно	Тамхи татахыг хориглоно



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг  
тээвэрлэх заавар**

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэлтэд бэлтгэх болон зам талбайгаар тээвэрлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх болон аюултай хог хаягдлыг шуудан, агаар, усан замаар тээвэрлэхэд энэхүү заавар хамаарахгүй бөгөөд тэдгээр нь олон улс болон дотоодод мөрдөгдөж буй дүрэм, зааврын хүрээнд зохицуулагдана.

**Хоёр. Хог хаягдлыг баглах, хаяглах**

- 2.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх нөхцөл, замын чичиргээ, температурын өөрчлөлт, чийгшил, даралт зэргээс хамаарч доторх зүйл асгарч гоожихгүй байхаар тээвэрлэхийн өмнө сайтар баглана.
- 2.2. Тээвэрлэлтэд бэлтгэсэн аюултай ачаа нь зориулалтын сав, баглаа боодлой, стандартын шаардлага хангасан англи эсвэл монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна.
- 2.3. Багласан хог хаягдлыг зориулалтын бат бэх, амархан цоорогооргүй, нүх сүвгүй, шингэн нэвчихгүй, таглаатай хуванцар саванд хийж гадна талд нь Хүснэгт 1-д үзүүлсний дагуу НҮБ-аас баталж гаргасан тусгай тэмдэглэгээг байрлуулна.

**Хүснэгт 1. Аюултай хог хаягдлын баглаа боодлын тэмдэглэгээ**


	4H2/Y94/S/08/MGL/001 Жин: 94 кг
--	------------------------------------

Энэхүү тэмдэглэгээ нь дараахь агуулгатай:

UN	НҮБ-ын баглаа боодлын тэмдэглэгээ		
4H2	Баглаа боодлын төрлийг тодорхойлно:		
	Эхний тоо (4)	Хоёр дахь үсэг (Н)	Гурав дахь тоо (2)
	1 - Торх	A - Ган	1 – Салдаг таг
	2-Төмөр торх	B – Хөнгөн цагаан	2– Салдаггүй, бэхэлгээтэй таг
	3 - Лааз	G – Цаасан хайрцаг	

	4 - Хайрцаг	Н - Хуванцар	
	5 - Цүнх	...	
4H2 = Салдаггүй, бэхэлгээтэй тагтай хуванцар хайрцаг			
Y94	Y = II болон III бүлэгт хамаарах халдвартай зүйлс 94 = Хатуу биет: Баглаа боодол дахь зүйлсийн жин нь 94 кг		
S	Зөвхөн хатуу биетэд хэрэглэнэ: S = Хатуу биет.		
08	Хог хаягдлыг багласан тухайн оны сүүлийн 2 орныг илэрхийлнэ: 08=2008		
MGL	<b>MGL</b> = Монгол улс		
001	Хог хаягдлыг тээвэрлэж буй байгууллагын код		

2.3. Аюултай хог хаягдал тээвэрлэх савны гадна талд 100 мм x 100 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 5 мм байна) “Биоаюултай” таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь НҮБ-ын эмнэлгийн хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд “Халдвартай эд зүйл” гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно(Зураг 1).



**Зураг 1. Аюултай хог хаягдал тээвэрлэх савны гадна талын таних тэмдэг**

2.4. Хог хаягдлын савны таних тэмдэг нь уншигдахуйц ил тод, ойлгомжтой, цаг агаарын аливаа үзэгдлийн нөлөөгөөр арилахааргүй байна.

#### **Гурав. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тээвэрлэлт, тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага**

3.1 Эмнэлгээс гадагш тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.2 Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан аюултай хог хаягдлыг нийтийн эзэмшлийн замаар тээвэрлэхэд тавигдах (UN 3291) шаардлагын дагуу эмнэлгийн хог хаягдлыг тээвэрлэнэ.

3.3 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг замын хөдөлгөөнд оролцох шаардлага бүрэн хангасан, тусгай таних тэмдэгтэй, (зураг 2) аюулгүй ажиллагааны заавар хангасан, битүүмжлэгдсэн, тусгайлан тоноглогдсон, хөргүүртэй, автотээврийн асуудал эрхэлсэн байгууллагаас тухайн төрлийн аюултай ачаа тээвэрлэхэд ашиглаж болох тухай тодорхойлолт, техникийн

хяналтын үзлэг, оношилгоонд орж тэнцсэн дүгнэлт гаргуулсан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.4 Аюултай ачааны тээвэрлэлтийг зөвхөн аюултай ачаа тээвэрлэх чиглэлээр мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлнэ.

3.5 Аюултай хог хаягдлыг цуглуулах чиглэл болон цагийн хуваарийг замын хөдөлгөөний хэв маяг, гудамж талбайн зохион байгуулалт, хог хаягдал цуглуулах байгууламж нь замын аль талд байрласан зэрэг хүчин зүйлсийг авч үзэн холбогдох мэргэжлийн байгууллагатай урьдчилан тохиролцож, тогтоосон зам /маршрут/-ын дагуу тээвэрлэнэ.

3.6 Хог хаягдлыг тээвэрлэгч байгууллага нь эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд үүсч буй хог хаягдлын хэмжээ, улирлаас шалтгаалж тээвэрлэх давтамжийг гэрээнд тусгасан байна.

3.7 Аюултай хог хаягдлыг тээвэрлэж дууссаны дараа тухайн тээврийн хэрэгслийг аюулгүй, хоргүй, халдвартгүй болгох арга хэмжээг авна.

3.8 Эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж нь хаягдал тээвэрлэсэн тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд тээврийн хэрэгслийн дугаар, тээвэрлэсэн он сар өдөр, хугацаа, хүний нэр, албан тушаалыг тодорхой бичнэ.

3.9 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл дараахь шаардлагыг хангана. Үүнд:

- Жолоочийн кабин болон ачааны хэсэг хоорондоо тусгаарлагдсан байх;
- Машины дотор тал нь цэвэрлэж халдвартгүйжүүлэх боломжтой байх;
- Стандартын шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгсэлтэй байх;
- Шингэн зүйлс гоожиход авах арга хэмжээний заавар, цэвэрлэх хэрэгсэл, халдвартгүйжүүлэгч бодис, хоосон нийлэг уут, бээлий, амны хаалт, шингээгч алчуур, хүрз зэрэг цэвэрлэгээний багаж;
- Хор саармагжуулах бодис, уусмал;
- Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын багаж, гал түймэр унтраах хэрэгсэл /галын хор, хүрз, шуудайтай элс, хувин г.м/;
- Яаралтай тохиолдолд хэрэглэх засварын хэрэгсэл;
- Машины хүндийн жин, дугуйны хэмжээнд тохирсон зогсоогч (механик тоормоз);
- Цахилгаанаас хамааралгүй асдаг 2 ширхэг шар гэрэл зэрэг болно.

3.10 Тээврийн хэрэгслийн гадна талд 250 мм x 250 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 12,5 мм байна) "Биоаюултай" таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь НҮБ-ын эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд "Халдвартай эд зүйл" гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно (Зураг2).




ЭСВЭЛ



Зураг 2. Тээврийн хэрэгслийн таних тэмдэг

3.11 Тээврийн хэрэгслийн урд болон ар талд галд тэсвэртэй материалаар хийгдсэн, улбар шар өнгөтэй 400 мм өргөн, 300 мм өндөр, 15 мм өргөнтэй хар өнгийн хүрээтэй анхааруулах тэмдгийг байрлуулна. Түүн дотор НҮБ-ын “аюул”-ыг илэрхийлсэн 606 болон 3291 дугаар бүхий тэмдэглэгээг 10 см-ын өндөр, 15 мм-ын өргөнтэйгөөр, хар өнгөөр бичнэ (Зураг 3). Тээврийн хэрэгслийн овор хэмжээнээс хамааран урд талын анхааруулах тэмдгийн өргөнийг 300 мм, өндрийг 120 мм, хүрээний өргөнийг 10 мм болгон багасгаж болно.



Зураг 3. Тээврийн хэрэгслийн анхааруулах тэмдэг

3.12 Жолооч замд гарахын өмнө тээврийн хэрэгслийн шалгах хуудсыг беглэж (Хүснэгт 3), тээвэрлэх үйл ажиллагаа дууссаны дараа жолооч эмнэлгийн хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.

#### Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн шалгах хуудас

А. Тээврийн хэрэгслийн техникийн шалгалт	Шалгасан (5 өдөр)				
	1	2	3	4	5
1. Тоормос ажиллагаатай					
2. Дугуйн хээ гүн, тод					
3. Дугуйны хий хангалттай					
4. Толь болон цонх цэвэр					
5. Шил арчигч ажиллагаатай					
6. Гэрэл болон мэдээллийн самбар ажиллагаатай					

7. Тээврийн хэрэгслийн гадна талд гэмтэл байхгүй				
<b>В. Хамгаалах хэрэгсэл</b>				
8. ABC Гал унтраагчтай, гал унтраагч ажилладаг				
9. Анхны тусламжийн хайрцагтай				
10. Асгарч, гэмтэхэд авах арга хэмжээний багаж хэрэгсэл бүрэн: Шингээгч материал, хүрз, 2 ш шар уут, халдвартайжүүлэх бодис, бээлий				
11. Аюулгүй ачиж, буулгах, тээвэрлэх хэрэгслүүд				
12. Анхааруулах гурвалжин тэмдэг				
13. Анхааруулах тэмдэг харагдахуйц тод, харагдахуйц байрлалтай				
<b>С. Баримт бичиг</b>				
14. Жолоочийн үнэмлэхтэй				
15. Хог хаягдлын хүлээлцэх бүртгэлийн маягт				
16. Баглаа боодлын таних тэмдэг, тэмдэглэгээтэй				
17. Эрсдлийг бүртгэх хуудас				
<b>Он сар болон гарын үсэг</b>				
1 дэх өдөр: Он сар / Гарын үсэг				
2 дахь өдөр: Он сар / Гарын үсэг				
3 дахь өдөр: Он сар / Гарын үсэг				
4 дэх өдөр: Он сар / Гарын үсэг				
5 дахь өдөр: Он сар / Гарын үсэг				

### Тусгай тэмдэглэгээ

---



---



---



---



---

### Дөрөв. Тээвэрлэлтийн үеийн ажилтны аюулгүй байдал

4.1. Аюултай хог хаягдлыг цуглуулагч, тээвэрлэгч нь аюулгүй ажиллагаатай холбоотой хууль, журам, дүрэм, стандартыг дагаж мөрдөнө.

4.2. Ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюултай ачаа тус бурийн хор аюулын лавлах мэдээлэл, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулсан байна. Эдгээр баримт бичиг болон тээвэрлэлтийн гэрээ /ачаа дагалдах бичиг/, замын хуудсыг жолооч заавал биедээ авч явна.

4.3. Хог хаягдлыг тээвэрлэх явцад аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул, эрсдлээс сэргийлэх үүргийг тээвэрлэгч хүлээнэ.

4.4.Хог хаягдлын хайрцаг, сав нь гэмтэлтэй, автотээврийн хэрэгсэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.

4.5.Тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүс хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсөнө.

4.6.Ажилтанг тархвар судлалын заалтаар болон сайн дурын дархлаажуулалтад хамруулна.

4.7.Тээврийн хэрэгслийн жолооч нь шаардлагатай хэрэгсэл, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, баримт бичгийг шалгах хуудсын дагуу тээвэрлэлт хийхийн өмнө тогтмол шалгана.

4.8.Ажилтныг аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэхтэй холбогдсон аргачлал, арга зүйн чиглэлийн сургалтад тогтмол хамруулна.

4.9.Тээвэрлэгч нь гал унтраах хэрэгслийг ашиглах талаар мэдлэгтэй байх бөгөөд тээврийн хэрэгсэл дотор болон ойр орчимд тамхи татахыг хориглоно.

4.10.Тээвэрлэлтийн үед, ачиж, буулгах явцад ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдооос сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлсэн байна.

4.11.Аюултай ачаа тээвэрлэх автомашиныг унтраасны дараа ачааг ачиж, буулгахыг зөвшөөрнө.

4.12.Тээвэрлэх үед зогсох шаардлага гарсан тохиолдолд уг тээврийн хэрэгслээс хоёр тийш 100м зайд "Орохыг хориглоно" тэмдгийг байрлуулна. Ийм ачаатай тээврийн хэрэгслийг хот, суурин газрын ойролцоо удаан хугацаагаар зогсохыг хориглоно.

4.13.Аюултай ачаатай авто тээврийн хэрэгслийг хот, суурин газарт зориулалтын бус гарааш, зогсоолд тавихыг хориглоно.

4.14.Аюултай хог хаягдал бүхий баглаа боодол, уут сав, хайрцаг зэргийг нээж үзэхийг хориглоно.

**Тав. Аюултай хог хаягдал тээвэрлэх явцад үүссэн эрсдлийн үеийн хариу арга хэмжээ**

5.1.Ослын аюултай талбайг тэмдэглэн зааглаж гадны хүмүүсийг өртөхөөс хамгаалж, шаардлагатай тохиолдолд 101, 102, 103, 105 тоот утсанд дуудлага өгнө.

5.2.Албан тушаалтануудад аюултай ачааны хор хөнөөлийн талаар танилцуулна.

5.3.Эрсдэлд өртсөн үед хувийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөнө.

5.4.Осолд өртсөн хүнд эмнэлгийн анхан шатны тусламжийг яаралтай үзүүлнэ. Үүнд:

5.4.1.Цусаар дамжих халдварт өртсөн үед зүссэн, хатгасан шархтай хэсгийг савантай усаар угаах;

5.4.2.Нүд үрүү биологийн шингэн үсэрсэн бол цэвэр ус эсвэл физиологийн уусмалаар угаах;

5.4.3.Химиин бодист хордсон үед хордсон газраас яаралтай холдож, цэвэр агаараар амьсгалуулж, бохирлогдсон хувцсыг яаралтай тайлах;

5.4.4.Арьс салстад хүрвэл 5-10% нашатырын спирт эсвэл савантай усаар угаах;

5.4.5.Холбогдох мэргэжилтэнээр халдвартын эрсдлийн үнэлгээ хийлгэж, бусад шаардлагатай арга хэмжээг авах зэрэг болно.

5.5. Жолооч осол аваарын талаарх дэлгэрэнгүй илтгэх хуудас бичиж, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламжийн хариуцах ажилтанд өгнө.

5.6. Халдвартай эд зүйлс арьсны бүрэн, бүтэн байдлыг алдагдуулж ажилтан нь цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдолд халдварлах эрсдлийг бууруулахын тулд өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.7. Эрүүл мэндийн ажилтан эрсдэлд өртсөн тохиолдол бүрийг бүртгэн, халдварын эрсдлийн үнэлгээг тархвар судлаач эмч, эмнэл зүйч эмчтэй хамтран хийн зөвлөгөө өгнө.

5.8. Улирал тутамд болсон ослын талаарх илтгэх хуудсыг хог хаягдлын нэгдсэн байгууламжийн /эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламжийн/ хариуцах ажилтан бэлтгэж эрх бүхий байгууллагад мэдээлнэ. Мэдээлэлд осол гэмтэлд хүргэсэн болон хор хохирол учруулсан шалтгааныг нь тогтоосон дүн шинжилгээ ба авсан арга хэмжээний талаар дурьдана.

5.9. Хог хаягдал асгарч гоожсон болон осол гарсан тохиолдолд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

5.9.1. Хог хаягдал унаж уутнаасаа асгарч гоожсон үед давхар уутанд хийн баглана.

5.9.2. Сав нь гэмтсэн бол давхар саванд хийх эсвэл өөр саванд зөөн шилжүүлнэ.

5.9.3. Шингэн хог хаягдал бага хэмжээтэй гоожсон үед нэг удаагийн алчуур, самбай тавин халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлсний дараа шингээж авах ба их хэмжээтэй бол элс, хөрс эсвэл өөр материалд шингээн авч шар уутанд цуглуулна.

5.9.4. Хэрвээ эд зүйлс усны эх үүсвэр, шугам хоолойд орсон бол холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5.10. Цус болон биологийн бусад шингэн асгарсан тохиолдолд халдвартай эд зүйлсийг цэвэрлэхдээ дараахь арга хэмжээг авна. Үүнд:

5.10.1. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл /хормогч, бээлий, амны хаалт, нүдний шил эсвэл нүүрний хаалт/ өмсөнө.

5.10.2. Бохирлогдсон гадаргууг эхлээд халдваргүйжүүлсний дараа ус болон угаалгын бодисоор цэвэрлэх;

5.10.3. Хэрэглэгдсэн хувийн хамгаалах хувцас хэрэгслийг халдвартай хог хаягдлын уут, саванд цуглуулж устгана. Гарыг халдваргүйжүүлнэ.

5.11. Түймэр гарсан тохиолдолд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үүнд:

5.11.1. Гал унтраагч ашиглан галыг түргэн унтраана.

5.11.2. Шатаагүй эд зүйлсийг галаас түргэн холдуулна.

5.11.3. Шаардлагатай тохиолдолд галын тусlamжийн дуудлага өгнө.

**Аюултай хог хаягдлын эрсдлийг бүртгэж мэдээлэх хуудас**

№	
1	Хугацаа /өн, сар, өдөр, цаг, минут/
2	Тээврийн хэрэгслийн マーク, дугаар
3	Жолоочийн овог нэр, утасны дугаар
4	Эрсдэл үүссэн газар
5	Эрсдлийн тухай мэдээлэл
6	Авсан арга хэмжээ
7	Мэдээлсэн албан тушаалтан, албан газар
8	Эрсдлийн үнэлгээний мэдээлэл
9	Бусад мэдээлэл
	Эрсдлийг бүртгэсэн хүний гарын үсэг

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
1/505 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах заавар

**Нэг. Эрүүл мэндийн байгууллагын халдвартай хог хаягдлыг өндөр парапттай уураар халдвартайжүүлэх**

Автоклавыг ашиглан өндөр даралт, халуун, чийгтэй уураар халдвартай хог хаягллыг халдвартайжүүлнэ.

## 1.1 Автоказын аюулгүй байдал

1.1.1. Автоклавтын асуулт түрүндийн  
1.1.1. Автоклавтай харьцах үед хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг  
бураэн хэрэглэж аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.

1.1.2. Автоклав ажиллаж эхлэхийн өмнө автоклавын хаалга бүрэн гүйцэт хаагдсан болон хавхлагууд найдвартай түгжигдсэн эсэхийг сайтар шалгана.

1.1.3.Урлын сувгийн бөглөрөл, төхөөрөмжийн буруу ажиллагаа зэргээс үүдэлтэй ус алдаж байгаа тохиолдолд халуун усанд түлэгдэх аюултай тул хаалгыг нэхийг хориглоно.

1.1.4.Халуун ууранд түлэгдэх, эмтэрсэн шилэнд зүсэгдэх зэрэг эрсдэлтэй тул автоклавын ариутгалын үе шат дуусч, даралт "Тэг" болсны дараа хаалгыг нээнэ.

1.1.5.Хэрэв шингэн асгарсан тохиолдолд автоклавыг гүйцэт хөрсний дараа нэн даруй цэвэрлэнэ.

1.1.6. Автоклавын камер дотор шил хагарсан тохиолдолд зориулалтын чимхүүр ашиглан цэвэрлэнэ. Бээлийтэй гараар цэвэрлэж болохгүй.

1.1.7. Уусгагч, ууршимтгай, хлорт нэгдлүүд (HCl, цайруулах) буюу идэмхий химийн бодис (тухайлбал: фенол, гурван хлорт цууны хүчил, эфир, хлороформ) гэх мэт агуулсан материал, эсэд хортой нөлөөтэй хог хаягдал, түүгээр бохирдсон материал, цацраг идэвхт материал, зарим хуванцар, хүнд металлын хог хаягдлыг автоклавт хийхийг хориглоно.

#### 1.2. Автоклавыг ажиллуулах үйл явц

1.2.1. Автоклавыг ашиглахын өмнө автоклав дотор өмнө үлдсэн байж болзошгүй эд зүйлс байгаа эсэхийг сайтар шалгана.

1.2.2. Автоклавын шүүлтүүр, хаалганы жийргэвчийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

1.2.3. Автоклавын усны түвшинг шалгаж, усаа зохих түвшин хүртэл шахна.

1.2.4. Автоклавын өдөр бурийн хяналтын бүртгэлийг байнга хянана.

### **1.3. Хог хаягдлыг автоклавт хийхэд бэлтгэх**

1.3.1.Хог хаягдлын уут, савны бүрэн бүтэн байдлыг сайтар шалгана.

1.3.2.Автоклавт хэрэглэж байгаа савнууд нь халуунд тэсвэртэй, дулаан дамжуулалт сайн, уурыг чөлөөтэй нэвтрүүлэх боломжтой байх бөгөөд амархан цоордоггүй, ус нэвтэрдэггүй байна.

1.3.3.Автоклавт "Pyrex" халуунд тэсвэртэй шил, полипропилен (PP) болон полиэтилен (PE) гэх мэт халуунд тэсвэртэй хуванцар, ган төмрөөр хийгдсэн савыг хэрэглэнэ.

1.3.4.Нийлэг ууттай хог хаягдал, латекс, винил, цаас, хуванцар соруурын хошуу, өсгөвөрийн аяга зэргийг зориулалтын сав, сагсанд хийж автоклавт халдвартгүйжүүлнэ.

1.3.5.Хуруу шил болон шилэн савнууд, биологийн шингэн агуулсан уут зэргийг өндөр даралтад тэсвэртэй саванд хийнэ. Битүү таглагдсан савны амыг бага зэрэг нээнэ.

1.3.6.Уутан доторх шингэн хальж асгарахаас сэргийлж уут, савыг  $\frac{3}{4}$  хэсгээс дээш дүүргэж болохгүй.

1.3.7.Автоклавт хийх материалыг зөөвөрлөхдөө аюулгүй байдлыг ханган зориулалтын тэргэнцэр, сав, тавиурыг ашиглана.

1.3.8.Хог хаягдал асгарсан үед авах арга хэмжээний бэлэн байдлыг урьдчилан хангасан байна.

### **1.4. Автоклавт хог хаягдлыг байрлуулах**

1.4.1.Автоклавын дотор хананд ямар нэгэн эд зүйлийг тулган тавихгүйгээр уут савтай хог хаягдлыг сийрэг байрлуулна.

1.4.2.Овор ихтэй, хүнд жинтэй хог хаягдлыг доод хэсэгт байрлуулна.

### **1.5. Автоклавыг ажиллуулах, ажлын горим**

1.5.1.Автоклавыг ажиллуулахаа үйлдвэрлэгчийн зааврыг чанд дагаж мөрднө.

1.5.2.Автоклавт хог хаягдлын материалын төрөл, хэмжээ зэргээс хамааран халдвартгүйжүүлэх хугацаа, халууны хэм өөр өөр байна.

1.5.3.Хог хаягдлыг автоклавт 121 °C-ийн хэмд 20 минут, 134 °C-ийн хэмд 10 минутын хугацаанд халдвартгүйжүүлнэ.

1.5.4.Хог хаягдлыг уураар халдвартгүйжүүлэх бүртгэлийн маягтыг бөглөнө /Хавсралт 3. Маягт 4/.

### **1.6. Автоклавын ажиллагааг дуусгах**

1.6.1.Хаалга бүрэн гүйцэд нээгдсэний дараа халуун ууранд түлэгдэхээс сэргийлж зориулалтын бээлий, ханцуивч, резинэн материалтай хормойвч, нүүрний хамгаалалт гэх мэт хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсөнө.

1.6.2.Хаалгыг нээсний дараа автоклавыг 10 минутаас доошгүй хугацаанд хөргөсний дараа халдвартгүйжүүлсэн хог хаягдлыг гаргана.

1.6.3.Автоклавын ажиллаж дууссан цагийг бүртгэлийн хуудсанд тэмдэглэн, автоклавын хаалга, тагийг нээлттэй орхино.

### **1.7. Халдвартгүйжүүлэлтийн хяналт, бүртгэл**

1.7.1. Автоклавын халдвартгүйжүүлэлтийн чанарыг хими, биологийн индикатораар тогтмол хянана. Химийн хяналтын өнгө хувиргагч цаасыг автоклавт хийж байгаа уут, сав нэг бүр дээр тус тус наана. Биологийн хяналтын индикаторыг улиралд 1 удаа автоклавт хийж хянана.

1.7.2. Автоклав доторх савны гүн хэсэг дэх хог хаягдлын халдвартгүйжүүлэлтийн чанарыг хянахдаа туузан индикаторыг нэг удаагийн пластик гуурс болон пипетканы үзүүрт тогтоож материалын гүнд хийж, савны гадна талд үлдсэн үзүүрийг тогтооно. Халдвартгүйжүүлэлт хийсний дараа индикаторыг сугалан авч өнгөний хувирлаар хяналт тавьж болно.

1.7.3. Автоклавын үйл ажиллагааг маягтын дагуу тогтмол хөтөлнө.

### **1.8. Автоклавын засвар үйлчилгээ**

1.8.1. Автоклавын хяналтын бүртгэлийг тогтмол хөтөлнө.

1.8.2. Автоклавын засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд болон холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэнэ.

1.8.3. Өдөр тутам дараах засвар үйлчилгээг заавал хийнэ. Үүнд:

1.8.3.1. Автоклавын гадна гадаргууг цэвэрлэнэ.

1.8.3.2. Хаалганы жийргэвчийг шалгана.

1.8.3.4. Цэвэр усны шугамыг цэвэрлэнэ.

1.8.3.5. Хог хаягдал хийх савны бүрэн бүтэн байдлыг шалгана.

1.8.3.6. Автоклавын дотор ханыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэнэ. Зүлгүүр ашиглахыг хориглоно.

1.8.4. Хяналт, засвар үйлчилгээг хийсэн тухай тэмдэглэгээг техник ашиглалтын паспортад тухай бүр бичиж тэмдэглэнэ.

### **Хоёр. Зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатаах**

2.1. Эрүүл мэндийн байгууллагын халдвартай, хурц иртэй, үзүүртэй, эмгэг, зарим төрлийн эмийн болон эсэд хортой хог хаягдлыг эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламжид агаарын бохирдлын хяналттай шатаах зууханд шатааж болно.

2.2. Шатаах зуухны ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, хог хаягдлын менежментийн сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна.

2.3. Нүүрний хамгаалалт, дулаанд тэсвэртэй бээлий, ажлын гутал гэх мэт хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд шаардлагатай хэрэгслийг зөв хэрэглэнэ.

2.4. Шатаах зуухны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэл хөтлөн, хэвийн үйл ажиллагааны алдагдал гарсан тохиолдолд засвар үйлчилгээний хэсэгт цаг алдалгүй мэдэгдэнэ.

2.5. Шатаах зууханд хог хаягдлыг хийх, шатаах, үнсийг зайлцуулах, ойр орчмыг цэвэр байлгах үүрэгтэй.

2.6. Шатаах зууханд дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.6.1.Шатаах зуух нь газ, дизель түлшээр ажиллах боломжтой, түлшээр тасралтгүй хангах төхөөрөмжтэй, түлш нөөцлөх савтай, цагт 50 килограммаас доошгүй хог хаягдлыг шатаах хүчин чадалтай байна.

2.6.2.Шатаах зуух нь 2 камертай байна. Камер бүр агаар болон түлшээр тасралтгүй хангах эх үүсвэрт холбогдсон байх бөгөөд агаар, дулааны автомат мэдрэгчээр тоноглогдсон байна.

2.6.3.Шатаах зуухны камериин дотор тал нь 1400 хэмд тэсвэртэй материалыаар хийгдсэн байна.

2.6.4.Шатаах зуух нь автомат тохируулгатай, хяналтын дэлгэцтэй байна.

2.6.5.Шатаах зуухны гадна талын гадаргуугийн халалт 50-55 хэмээс ихгүй байх шаардлагатай ба термометр сууринуулсан байна.

2.6.6.Шатаах зуухны анхдагч болон хоёрдогч камериин дулаан бууралтыг мэдрэгч нь дуут болон гэрлэн дохио өгөх төхөөрөмжтэй байна.

2.6.7.Агааржуулалтын автомат тохируулгатай байна.

2.6.8.Шатаах байгууламжинд гадны хүн орохыг хориглоно.

2.6.9.Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйцаар бичиж хананд байрлуулсан байна.

## 2.7.Зууханд хог хаягдлыг шатаах:

2.7.1.Зууханд шатаах хог хаягдлын чийглэг 30 хувиас ихгүй, шатах материалын агууламж 60 хувиас их байна.

2.7.2.Зуухны анхдагч камер дахь дулаан 850 хэмээс багагүй, хоёрдогч камер дахь дулаан 1100 хэмд хүрсэн нөхцөлд зууханд хог хийх системийг ажиллуулж, хогийг тохирох хэмжээгээр хийнэ.

2.7.3.Хог хаягдлыг камер тус бүрт 2 секундээс доошгүй хугацаанд, бүрэн шатаж дуустал байлгана.

2.7.4.Зуухны үнсийг тусгай зориулалтын тагтай саванд цуглувалж хадгалах бөгөөд зориулалтын ландфилд устгана.

2.7.5.Зуухны бохирдлыг цэвэрлэхэд ашигласан бохир ус болон тортогийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл саармагжуулсны дараа төвлөрсөн бохирын шугамд нийлүүлнэ.

2.7.6.Шатаах зуухнаас ялгарч буй утаа, үнсэнд 3 сар тутамд чанарын хяналт хийнэ.

## 2.8.Зууханд шатаахад дараах зүйлсийг шатаахыг хориглоно. Үүнд:

2.8.1.Зуухан дахь хог хаягдал бүрэн шатаагүй тохиолдолд нэмж хийхийг хориглоно.

2.8.2.Шатаах зуухан дахь халуун зохих хэмжээнд хүрээгүй, агаар хөргөлтийн сэнс, дэлгэц, агаарын бохирдлын хяналтын систем доголдолтой эсвэл хэт халуун байх үед шатаах зууханд хог хаягдлыг хийж болохгүй.

2.8.3.Даралтат сав, ихээхэн хэмжээний химийн бодис, урвалж, мөнгөний давс, фотохимийн болон цацраг идэвхт бодис, ПВС агуулсан зүйлс /цусны уут, дуслын систем, нэг удаагийн тариур/, мөнгөн ус, кадми агуулсан

хэрэгсэл, дэлбэрэх аюултай зүйлс, хлор бүхий химиин бодис бүхий зүйлсийг шатааж устгахыг хориглоно.

2.8.4.Агаарын бохирдлын хяналтын систем суурилаагүй шатаах зуух ашиглахыг хориглоно.

2.8.5.Шатаах зуухны үйл ажиллагаа, засвар үйлчилгээний хуваарийг өдөр тутам, долоо хоног, сар, жилээр гарган бүртгэл хөтөлнө.

#### **Гурав. Капсулдах арга**

3.1.Эмийн болон эсэд хортой хог хаягдлыг төмөр саванд 50 хувь хүртэл хортой эмийг, 15:15:5 харьцаатайгаар цемент, шохой, усыг сайтар хольж дүүргэн савны тагийг гагнаж лацдан 7-28 өдрийн дараа газарт булж, дээрээс нь шингэн нэвчихгүй шавар давхарга хийнэ.

#### **Дөрөв. Эхсийн нүхэнд тавигдах шаардлага, ашиглах заавар**

4.1.Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламж байхгүй газарт буюу хөдөө орон нутагт мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас, хүн, амьтны цогцос, эдийн шинжилгээний лааны тосон цутгамаг зэргийг эхсийн нүхэнд хийнэ.

4.2.Эхсийн нүхэнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

4.2.1.Эхсийн нүх нь аймаг болон сумын түвшний эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээнээс гарсан халдвартай бус, эмгэг хог хаягдлыг халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан устгахад зориулагдана.

4.2.2.Эхсийн нүх нь ашиглалтын явцад ил задгай болон гүний усны эх үүсвэр, хөрс агаарыг бохирдуулахгүй байх, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгаль орчныг хамгаалах нөхцлийг хангасан байна.

4.2.3.Усны эх, ундарга, нөөцийг бохирдооос хамгаалах зорилгоор үерт автхаарагүй, хөрсний элэгдэлгүй газарт газрын гүний уснаас 2 м-ээс дээш түвшинд байрлана.

4.2.4.Эмнэлгийн хашаан дотор, эмнэлгийн барилгаас 5-15 метр, ус түгээх цэгийн байрнаас 20 метр, өрөмдмөл худгаас 150-250 метр, голын эргээс 200-250 метрээс багагүй зайд, тухайн газар нутгийн зонхилох салхины чиглэлийн доод талд байрлана.

4.2.5.Эмнэлгийн хашаанд байрлуулах боломжгүй тохиолдолд эхсийн нүх байрлуулах газрыг тухайн газар нутгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчтай зөвшилцэн сонгоно.

4.2.6.Мал, амьтан орохгүй газар байрлах бөгөөд битүүмжлэл сайтай байна.

4.2.7.Эхсийн нүхний хэмжээг тухайн эмнэлгийн төрөлтийн тоо, хөрсний нэвчүүлэх чадвараас хамаарч сонгох бөгөөд эхсийн нүх нь 1 метрээс багагүй диаметртэй, 2 метрээс доошгүй гүн байна.

4.2.8.Нүхний хажуу ханыг шавар эсвэл цементийн зуурмагаар 10 см-ийн зузаан доторлож, тэгшлэх бөгөөд ёроолыг бүрэхгүйгээр хэвээр нь үлдээнэ.

4.2.9. Эмгэг хог хаягдлын хаталтыг түргэтгэх үүднээс нүхний ёроолд 40-80 мм-ийн диаметр бүхий чулуугаар 0,1 метрийн өндөртэй үе хийж, дараагаар нь 20-40 мм-ийн диаметр бүхий хайрга чулуугаар 0,4 метрийн өндөртэй үе хийнэ.

4.2.10. Нүхний амсар дээр шургааг, төмөр эсвэл төмөр бетон зэргийг дамнуулан тавьж, эргэн тойронд 100 см-ийн радиустай цементэн зуурмагаар бетондож, нүхний гол хэсэгт 20-40 см-ийн радиустай битүүмжлэл сайтай, гадагш нээгддэг бариул бүхий төмөр таг суурилуулах бөгөөд таглааг байнга хаалттай байлгаж цоожилно.

4.3. Эхсийн нүхийг дараахь байдлаар ашиглана. Үүнд:

4.3.1. Нүхэнд эмгэг хог хаягдлаас бусад зүйлийг хийж болохгүй.

4.3.2. Хлор агуулсан химийн бодис нь хөрсний pH орчныг нэмэгдүүлснээр эмгэг хог хаягдлын задралыг удаашруулдаг тул эмгэг хог хаягдал болон эхсийн нүхэнд халдвартгуйжүүлэлт хийж болохгүй. Эхсийн нүхнээс гарах үнэрийг дарах зорилгоор нүүрс, үнс хийж болно.


4.3.4. Эмгэг хог хаягдлыг эхсийн нүхэнд хаяхдаа хамгаалах хувцас, хэрэгсэл тухайлбал бээлий өмсөж, амны хаалт, шил буюу нүүрний хаалт зүүж, хог хаягдлыг гялгар уутгүйгээр нүхэнд шууд хийнэ.

4.3.5. Эмгэг хог хаягдал агуулж байсан савыг цэвэрлэж халдвартгуйжүүлнэ.

4.3.6. Эхсийн нүхний амсраас доош 0,5 метр хүртэл дүүрэхэд модны нүүрсээр бүрхэж, хөрсөөр дүүргэн битүүмжлэн булна. Нунтаг үнс хэрэглэж болохгүй.

4.3.7. Эхсийн нүхэнд дэх эмгэг хог хаягдлын бүрэн задрал явагдах хугацаа нь тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалах бөгөөд эхсийн нүхийг битүүмжилснээс хойш доод тал нь 2 жил дахин ашиглахгүй.

Зураг. Эхсийн нүхний бүдүүвч зураг



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12.-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

**Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах  
төвлөрсөн байгууламжид тавигдах шаардлага**

**Нэг. Нийтлэг зүйл:**

- 1.1. Энэхүү заавар нь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламжид мөрдөгднө.
- 1.2. Төвлөрсөн байгууламжийн үйлчлэх хүрээ нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс 150 км-ийн радиусаас ихгүй байна.
- 1.3. Төвлөрсөн байгууламж нь зориулалтын барилга, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинтэй, батлагдсан журам, зааврын дагуу үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна.
- 1.4. Төвлөрсөн байгууламжид байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийгдсэн байна.
- 1.5. Энэхүү зааварт тусгагдаагүй бусад асуудлыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль, дүрэм, журмаар зохицуулна.

**Хоёр. Төвлөрсөн байгууламжийн барилгад тавигдах ерөнхий шаардлага**

- 2.1. Батлагдсан зураг төсөл, стандарт, барилгын норм, дүрмийн дагуу баригдсан, улсын комисст хүлээлгэн өгсөн, зориулалтын барилга бүхий төвлөрсөн байгууламжид ЭМБХХ-ыг боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулна.
- 2.2. Төвлөрсөн байгууламж нь нийтийн суурьшлын бүс болон олон нийтийн газраас зйтай, ундны усны эх үүсвэрээс хол, үерт автахааргүй газарт хот суурингийн зонхилох салхины доор байрлана.
- 2.3. Байгууламж нь цэвэр, бохир усны хэсгийн болон төвлөрсөн системд холбогдсон, цахилгааны төвийн эх үүсвэртэй, үерийн далан, сувагтай, бохир ус цэвэрлэх байгууламжтай байна.
- 2.4. Хог хаягал боловсруулах төвлөрсөн байгууламжийн барилга нь ажиллагсдын амрах, усанд орох, хооллох өрөө болон захиргаанаас тусдаа байрлана.
- 2.5. Тээврийн хэрэгсэл саадгүй хүрэх, барилга, зам байгуулах боломжтой газар байвал зохино.
- 2.6. Мал амьтан, гадны хүн орохооргүй, хашаа хамгаалалттай, байнгын харуултай, гадна талдаа хаяг, биоаюулгүй таних тэмдэг байрлуулсан, 1,8 га-с баагүй эдэлбэр газартай, эдэлбэр газрын 60%-аас доошгүй газарт ногоон байгууламжтай байна.

2.7. Гадны хүн, амьтан орохоос сэргийлж, цоожтой хаалга бүхий хашаатай, хашааны өндөр нь 1,8 метрээс багагүй байна. Бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.

2.8. Шингэн хаягдал гадагш урсахгүй, хор хөнөөлийг бууруулах арга хэмжээ авах боломжтой байна.

2.9. Барилга нь 8-10 баллын газар хөдлөлтөнд тэсвэртэй байх бөгөөд утаа мэдрэгч тоног төхөөрөмж, аянга зайлцуулах газардуулгатай байна.

2.10. Аюулгүй байдлын үүднээс байгууламжийн хашаанд онцгой байдал, ослын үед байрны өөр талаас нь нэвтрэх зорилгоор нэмэлт хаалга гаргаж болно.

### **Гурав. Барилгын зохион байгуулалт, тавигдах шаардлага**

3.1. Төвлөрсөн байгууламж нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

3.1.1. Аюултай хог хаягдал хүлээн авах хэсэг /цуглуулсан хог хаягдлыг тээврийн хэрэгслээс буулгаж, жигнэж, бүртгэнэ/

3.1.2. Түр хадгалах хэсэг /халдвартай болон эмгэг хог хаягдлыг ЭМБХХ-ыг боловсруулах тоног төхөөрөмжийн эвдрэл, ачаалал ихтэй үед 48 цаг хүртэл хугацаагаар хадгална/

3.1.3. Халдвартайжүүлэх хэсэг /халдвартай хог хаягдлыг хадваргүйжүүлж бутална/

3.1.4. Халдвартайжүүлсэн хог хаягдлыг түр хадгалах хэсэг /халдвартайжүүлсэн хог хаягдлыг эцсийн устгалын цэг рүү тээвэрлэх хүртэл түр хадгална/

3.1.5. Тээврийн хэрэгсэл, хогийн сав угаах, халдвартайжүүлэх хэсэг /хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгслийг хадваргүйжүүлж, угааж цэвэрлэнэ/

3.1.6. Цэвэр хогийн сав хадгалах хэсэг /халдвартайжүүлж, цэвэрлэсэн хог хаягдлын сав, тэргэнцэрийг хадгална/

3.1.7. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн хэсэг / техник хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах хэрэгсэл тухайлбал, уур үүсгэгч, даралттай агаарын генератор, ус зөөлрүүлэгч гэх мэт болон засвар үйлчилгээний зүйлсийг хадгална/

3.1.8. Захиргааны хэсэг/ оффис

3.1.9. Ажилчдын амрах өрөө

3.1.10. Хувцас сольж хадгалах өрөө

3.1.11. Угаалгын өрөө

3.1.12. Усанд орох өрөө

3.1.13. Хоолны газар

### **Дөрөв. Хүний нөөцөд тавигдах шаардлага**

4.1. Төвлөрсөн байгууламж нь өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай мэргэжилтэн, сургагдсан ажилтантай байна. Үүнд:

4.1.1. Эрүүл ахуйч, тархвар судлагч

4.1.2. Тоног төхөөрөмжийн инженер

4.1.3. Автоклавын оператор

4.1.4. Шатаах зуухны оператор

- 4.1.5.Бутлагч машины оператор
- 4.1.6.Угаагч
- 4.1.7.Жолооч /Аюултай хог хаягдлын тээврийн хэрэгсэл бүрт/
- 4.1.8. Ачигч /Аюултай хог хаягдлын тээврийн хэрэгсэл бүрт, төвлөрсөн байгууламжид ээлж бүрт/
- 4.1.9.Үйлчлэгч

4.2. Бүх ажилтнууд нь сертификат бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн холбогдох сургалтуудад хамрагдсан байна.

4.3. Бүх ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгийн журамд заасан үзлэг шинжилгээнд хамрагдахаас гадна В вируст хепатит, татрангийн эсрэг дархлаажуулалтанд заавал хамрагдсан байна.

4.4.Хувийн хамгаалах хэрэгслээр тухайлбал, нүүрний хамгаалалт, дулаанд тэсвэртэй бээлий, ажлын гутал гэх мэт хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд шаардлагатай хэрэгслийг зөв хэрэглэнэ.

4.5.Шатаах зуухны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэл хөтөлнө.

4.6.Шатаах зуухны хэвийн үйл ажиллагааны алдагдал гарсан тохиолдолд засвар үйлчилгээний хэсэгт цаг алдалгүй мэдэгдэнэ.

4.7.Шатаах зууханд хог хаягдлыг хийх, шатаах, үнсийг зайлуулах, ойр орчмыг цэвэр байлгах үүрэгтэй.

#### **Тав. Хог хаягдлыг шатаах байгууламжид тавигдах шаардлага**

5.1.Энэхүү заавар нь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг шатаах аргаар боловсруулах байгууламжид хамаарна.

5.2.Шатаах байгууламж нь шатаах зуух бүхий өрөө, шаталтын дараах хэсэг, агаарын бохирдлын хяналтын хэрэгсэл, хаягдал ус боловсруулах хэсгүүдтэй байна.

5.3.Шатаах байгууламжийн хана, шал, таазыг галд тэсвэртэй материалыар хийнэ.

5.4.Шатаах зуух бүхий өрөө нь хог хаягдлыг түр хадгалах өрөөтэй холбогдсон, хана, таазнаас 1,5 метрээс доошгүй зйтай байна.

5.5.Шатаах зуухыг эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламжид ашиглахыг зөвшөөрнө.

5.6.Хог хаягдлыг зуух руу хийх автомат системтэй байна.

5.7.Шатаах хэсэгт дулааныг тохиромжтой түвшинд барьж байхын тулд автоматаар ажилладаг асаагуур суурилуулна.

5.8.Шатаах зуухны дулаан, даралтын уналт, угаарын хий, нүүрстөрөгчийн давхар исэл, хүчилтөрөгчийн түвшин зэрэг чухал шаардлагатай шаталтын гол үзүүлэлтүүдийг тасралтгүй хянаж байх системтэй байна.

5.9.Агаарын бохирдлын хяналтын систем суурилаагүй шатаах зуух ашиглахыг хориглоно.

5.10.Агаарын бохирдлын хяналтын систем нь яндан дахь дэгдэмхий бодис, хорт хийг цэвэрлэх чийгтэй системтэй байна.

5.11.Шатаах байгууламжинд гадны хүн орохыг хориглоно.

5.12. Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйц том, тод бичиж хананд байрлуулсан байна.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 6 дугаар хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд шаардлагатай  
хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт**

Д/ Д	Тоног төхөөрөмжийн нэр	Төв эмнэлэг	Тусгай мэргэжлийн төв	Түргэн тусламжийн төв	Сувилал	БОЭТ, аймгийн нэгдсэн эмнэлэг	Дуургийн ЭМТ, нэгдсэн эмнэлэг	Амаржих газар	Клиник	Сум дундын эмнэлэг	Сум, тосгоны ЭМТ	Өрхийн ЭМТ

**Хувийн хамгаалах хэрэгсэл**



1	Хамгаалах нүдний шил	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
2	Нүүрний хамгаалалт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
3	Химийн бодисттэсвэртэй бээлий	+	+			+	+	+				
4	Зүү нэвтэрдэггүй бээлий	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
5	Ахуйн бээлий	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
6	Халуунд тэсвэртэй ажлын бээлий*	+	+			+	+			+	+	
7	Ажлын хувцас/ комбинzon эсвэл өмд цамц, хүрээм	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
8	Хормогч, ханцуйвч	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
9	Хамгаалалттай ажлын гутал	+	+	+		+	+	+	+	+	+	
10	Химийн бодист тэсвэртэй ажлын гутал	+	+			+	+	+		+	+	



**Тоног төхөөрөмж, хэрэгсэл**

1	Хог хаягдлын нийлэг уут /шар, хүрэн, хар/	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
2	Халдвартай хог хаягдлын хогийн сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
3	Халдвартай хог хаягдал түр хадгалах сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
4	Халдвартай хог хаягдал зөөвөрлөх тэргэнцэр	+	+		+	+	+	+	+	+	+	+
5	Аюулгүйн хайрцаг	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
6	Ахуйн хог хаягдал цуглуулах сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
7	Ахуйн хог хаягдал зөөвөрлөх дугуйтай тэргэнцэр	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
8	Хог хаягдал зөөвөрлөх тэргэнцэр	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
9	Өдрийн гэрэл хадгалах сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+

10	Хэрэглээнээс гарсан зай цуглуулах сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
11	Жин	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
12	Автомакс	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
13	Даралттай ус шүршигч, уртасгагч усны хоолой	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
14	Химийн бодис хадгалах тавиур	+	+			+	+	+				
15	Хөргөгч	+	+			+	+	+				
16	Лабораториос үүсэх амьд үүсгэгч агуулсан өсгөвөр, тэжээлт орчинг халдвартгуйжүүлэх автоклав	+	+			+	+					
17	Хог хаягдлыг халдвартгуйжүүлэх автоклав					+				+	+	
18	Бутлагч					+						

**Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд шаардлагатай  
хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, тавигдах шаардлага**

№	Тоног төхөөрөмж	Тавигдах шаардлага	Зориулалт	Жишиг зураг
<b>Нэг. Эмнэлгийн хог хаягдлыг цэвэрлэх, халдвартгуйжүүлэх тоног төхөөрөмж</b>				
1.1.	Автомакс	Дараахь дагалдах хэрэгсэл: -Гангаар хийгдсэн шүршигч хэсэг, -Даралттай шүршигч хоолой, -Дараад хялбар гох, мөрөнд тогтоогч	Сав, хогийн сав, бусад зүйлсийг цэвэрлэх, халдвартгуйжүүлэх зориулалт бүхий шүршигч	
1.2.	Усны хоолой	Материал: Хуванцар	Урд талд нь хошуу хийж хог хаягдлын тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх, хадгалах сав, тэргэнцэр цэвэрлэх зориулалт бүхий усны хоолой	
1.3.	Даралтат ус шүршигч /зөөврийн/	Дараахь дагалдах хэрэгсэл: -Гангаар хийгдсэн шүршигч хэсэг, -Даралттай шүршигч хоолой, -Дараад хялбар гох, -220V, 50Hz ажиллах боломжтой	Хог хаягдлын тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх, хадгалах сав, тэргэнцэр, хана шалны бохир хэсгийг даралттай усаар шүршиж цэвэрлэх	
1.4.	Бага оврын автоклав	Камерын хэмжээ: >60 литр Материал: Зэвэрдэггүй ган Температур: 121°C, 134°C	Халдвартай хог хаягал халдвартгуйжүүлэх зориулалт бүхий автоклав	
1.5.	Том оврын автомат автоклав	Камерын хэмжээ: > 250 литр Материал: Зэвэрдэггүй ган Температур: 121°C, 134°C  Дагалдах хэрэгсэл: -Хог ачаалах тэргэнцэр, сагс -Ус зөөлрүүлэгч -Агаарын компрессор	800 хүртэл ортой эмнэлэгт халдвартай хог хаягал халдвартгуйжүүлэх зориулалт бүхий автоклав	
1.6.	Автоклавын	-Химийн индикатор бүхий	Автоклавын	

	чанарыг хянах хэрэгслийн иж бүрдэл	тууз -Биологийн спор бүхий сорил (Bacillus Stearothermophilus) -Спор бүхий сорилыг байрлуулах инкубатор -Боуи-Дикийн сорил (зөвхөн вакуум автоклаванд)	халдвартгүйжүүлэлтийн чанар шалгах	
1.7.	Ус шахагч насос	Цахилгаан: 220 V, 50 Hz	Холбогдох тоног төхөөрөмжид шаардлагатай усны даралтыг 4 бар хүртэл нэмэгдүүлж, үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах	
1.8.	Автоклавын ус шүүгч	Шүүгч: сольдог	Автоклавт хэрэглэгдэх усыг шүүх	
1.9.	Цахилгааны хүчдэл тогтворжуулагч	Автомат тохируулгатай	Цахилгаан хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүчдэлийн хэлбэлзлээс шалтгаалсан үйл ажиллагааны доголдлоос сэргийлэх	

Хоёр. Хог хаягдал цуглуулах, хадгалах, зөөвөрлөх, тээвэрлэх хэрэгсэл


2.1.	Хог хаягдлын уут	<p>Зузаан: 7 микроос доошгүй</p> <ul style="list-style-type: none"> <li>-Зөвхөн нэг удаа ашиглана</li> <li>-Автоклавдах боломжтой</li> <li>-Шар болон хүрэн уутан дээр “Биоаюултай” таних тэмдэгтэй</li> <li>-Шар, хүрэн, хар өнгөтэй</li> </ul>	Тасаг, нэгж, лаборатори зэрэг газруудаас халдвартай хог хаягдал цуглуулахад ашиглах хэрэгсэл	
2.2.	Хог хаягдлын жижиг хогийн сав	<p>Материал: Хуванцар (PE-полиэтилен)</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хөнгөн, зөөхөд хялбар</li> <li>-Угаалга, халдвартгүйтгэлийн бодист тэсвэртэй</li> <li>-Тагтай</li> <li>-Хөлөөрөө дарж онгойлгодог</li> <li>-Цэвэрлэхэд хялбар, мөлгөр гадаргуутай</li> <li>-Шар өнгөтэй</li> <li>-“Биоаюултай” таних тэмдэгтэй</li> </ul>	Тасаг, нэгж, лаборатори зэрэг газруудаас халдвартай хог хаягдал цуглуулахад ашиглах хэрэгсэл	
2.3.	Аюулгүйн хайрцаг	<p>Материал: Хуванцар, цаасан</p> <ul style="list-style-type: none"> <li>-“Биоаюултай” таних тэмдэгтэй</li> <li>-Хуванцар аюулгүйн хайрцаг нь тагтай, зүү мултлагчтай байна.</li> <li>-Шингэн нэвтэрдэггүй</li> <li>-Зүү нэвтэрдэггүй</li> <li>-Автоклавдах боломжтой</li> </ul>	Хурц иртэй, үзүүртэй хог хаягдал цуглуулахад ашиглах хэрэгсэл	  

2.4.	Ахуйн хог хаягдлын хогийн сав	Материал: Хуванцар (ПЕ-полиэтилен) -Хөнгөн, зөөхөд хялбар -Угаалга, халдвартгүйжүүлэх бодист тэсвэртэй -Тагтай -Хөлөөрөө дарж онгойлгодог -Цэвэрлэхэд хялбар, мөлгөр гадаргуутай -Хар/саарал өнгөтэй	Аюулгүй хог хаягдлыг (ахуйн хог хаягдал) цуглуулах зориулалттай	
2.5.	Ахуйн хог хаягдал зөөвөрлөх зориулалт бүхий дугуйтай хогийн сав	Материал: Өндөр нягтралтай хуванцар -Эрсдэлгүй, хатуу хог хаягдал хийх зориулалттай -Хэт ягаан туяа, өндөр хэмд тэсвэртэй -Хог наалдахаас сэргийлсэн гөлгөр гадаргуутай -Химийн болон биологийн нөлөөнд тэсвэртэй -Хар/саарал өнгөтэй	Ахуйн хог хаягдал бүхий ууттай хогийг цуглуулж зөөвөрлөх	
2.6.	Аюултай хог хаягдал цуглуулах сав	Материал: Нягтрал сайтай хуванцар -Хөнгөн, зөөхөд хялбар -Хүчил, шүлтэд тэсвэртэй -Цэвэрлэхэд хялбар -2 талдаа бариултай -Таг нь түгжигддэг -Шар өнгөтэй, “Биоаюултай” таних тэмдэгтэй	Аюултай хог хаягдал бүхий ууттай хог хаягдлыг тасаг, нэгжид түр хадгалах, зөөвөрлөх	
2.7.	Аюултай хог хаягдал цуглуулах, зөөх тэргэнцэр	Зөөверлөхөд хялбар дугуйтай байх Материал: Төмөр, металл	Аюултай хог хаягдал бүхий савыг зөөвөрлөх	
2.8.	Аюултай хог хаягдал зөөвөрлөх сав	Материал: Өндөр нягтралтай хуванцар (HDPE) -Сав нь 1м-ээс өндөргүй байх	Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх	

2.9.	Өдрийн гэрэл хадгалах сав	Материал: Төмөр/ өндөр нягтралтай хуванцар (HDPE) -Түгжигддэг, тагтай байх -Гадна талдаа 3/4хэсэгт таних тэмдэгтэй -2 талдаа бариултай -Бат бөх, давхарлаж тавих бололцоотой байх	Хагарсан, шатсан өдрийн гэрэл, чийдэн цуглуулах, зөвөрлөх	
2.10.	Аюултай хатуу хог хаягдал тээвэрлэх сав	Материал: Полиэтилен -Авагддаг тагтай байх -Гадна талдаа таних тэмдэг тавих хэсэгтэй -Бат бөх, давхарлаж тавих бололцоотой байх	Эрүүл мэндийн байгууллагаас гарах аккумулятор, зайд болон бусад хүнд металл агуулсан багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цуглуулж хадгалах	
2.11.	Жин –электрон	-Цэвэрлэх, халдвартгуйжүүлэхэд хялбар -Хэмжих, уншихад хялбар -Ус нэвтэрдэггүй материалаар хийгдсэн байх	Эрүүл мэндийн байгууллагын төрөл бүрийн хог хаягдлыг жигнэх	
2.12.	Химийн бодисын хог хаягдал хадгалах тавиур	Материал: цайрдсан ган, зэвэрдэггүй  -Тогтвортой, унахаас сэргийлж нэмэлт бэхэлгээ хийх	Хатуу болон шингэн химийн хог хаягдлыг хадгалах	

2.13.	Химиин бодисыг аюулгүй хадгалах сав	Материал: Хэт ягаан туяа болон химиин бодист тэсвэртэй хуванцар(РЕ) -Савнуудыг тээвэрлэхэд хялбар болгох үүднээс тавиур дээр тавих боломжтой байх -Савны гадарыг цэвэрлэхэд хялбар байх -Эргэгдэг таглаатай байх	Идэмхий шүлт, хүчил, фотохимийн бодис зэрэг шатамхай бус шингэн, химиин бодис хадгалах	
2.14.	Шингэн цуглуулах тавиур	Материал: Хэт ягаан туяанд тэсвэртэй Полиэтилен (РЕ) -Шингэн химиин бодистой савыг тавиур дээр тавих -Цэвэрлэхэд хялбар	Шингэн, химиин бодис асарахад цуглуулах зориулалт бүхий тавиур	
2.15.	Автомашин	Гидролик өргөгч Бүхээгтэй -Ачааны бүхээг хөргүүртэй -Бүхээг нь цоожлогддог -Дугуйтай тэргэнцрийг өргөгчөөр ачих боломжтой -Шал нь тэгш гадаргуутай	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх	


#### Гурав. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл

3.1.	Хамгаалах нүдний шил	Материал: Зурагддаггүй хуванцар -Цантдаггүй -Уяаг толгойд тааруулах боломжтой	Нүд хамгаалах хэрэгсэл	
3.2.	Нүүрний хаалт	Материал: Зурагддаггүй хуванцар -Цантдаггүй -Уяаг толгойд тааруулах боломжтой	Нүд хамгаалах хэрэгсэл	
3.3.	Ажлын бээлий	Материал: Хуванцар бүрэлттэй зузаан бөс даавуу	Химиин бодистой харьцах, бохирын системтэй ажиллах явцад хэрэглэх	

3.4.	Зүү нэвтэрдэггүй бээлий	Материал: Нэхмэл кевлар доторлогоотой, нитрил бутадиен гадаргатай, тефлон ган ялтсаар хийгдсэн байна Үрэлтэд тэсвэртэй байдал: (1-4): Түвшин 3 Зүсэлтэд тэсвэртэй байдал: (1-5): Түвшин 5 Урагдаггүй байдал: (1-4): Түвшин 4 Хатгалт, цоололтод тэсвэртэй байдал: (1-4): Түвшин 4	Хурц үзүүртэй, иртэй зүйлд хатгуулсны улмаас гэмтэл авах, хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллах явцад зүсэх, хатгуулахаас хамгаалах зориулалт бүхий хувийн хамгаалах хэрэгсэл	
3.5.	Ахуйн бээлий	Материал: Нитрил гадаргуутай бат бөх сүлжмэл	Аюулгүй материалтай (ахуйн хог хаягдал, дахин боловсруулах хог хаягдал г.м.) харьцах ажиллах зориулалт бүхий хувийн хамгаалах хэрэгсэл	
3.6.	Халуунд тэсвэртэй ажлын бээлий	Материал: Кевлараар хийгдсэн Аюулгүйн ангилал: CE 3	Хог хаягдалтай уутыг өндөр даралттай уураар халдвартгүйжүүлэх автоклав, шатаах зууханд хийх, гаргаж авахад ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	
3.7.	Хамгаалах ажлын хувцас / комбинзон эсвэл өмд цамц	Материал: Хөвөн даавуу -Сайн чанарын, бат бөх, угааж цэвэрлэхэд хялбар, урдуураа цахилгаантай -Энгэртээ 2 цахилгаантай кармataй, ар ташаандaa 2 том, цахилгаан бүхий кармataй	Хог хаягдалтай уутыг өндөр даралттай уураар халдвартгүйтгэх автоклав, шатаах зууханд хийх, гаргаж авахад ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	
3.8.	Хормогч, ханцууйвч	Материал: Хулдаас -Химийн бодист тэсвэртэй -Шингэн нэвтрүүлдэггүй	Шингэн бодистой харьцах, хог хаягдлын сав, тэргэнцэрийг халдвартгүйжүүлэх, угаах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	
3.9.	Хамгаалалт бүхий ажлын гутал	Материал: Шир Давхар нягтралтай полиуретан Аюулгүйн ангилал:EN345 (200 Жоуль). -Ширэн гадартай, доторлогоотой -200 °C халуунд тэсвэртэй, ган улавчтай -Бензин, тос, хүчил,	Хөл хамгаалах хувийн хэрэгсэл	

		шүлтэнд тэсвэртэй, цахилгаанждаггүй материалаар хийсэн ултай		
3.10.	Химийн бодист тэсвэртай хамгаалалты н ажлын гутал	Материал: Полистер Аюулгүйн ангилал: EH 345 (200 Жоуль) -PVC гадна талтай -Бензин, тос, хүчил, шүлтэнд тэсвэртэй,	Хөл хамгаалах хувийн хэрэгсэл	

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалын 7 дугаар хавсралт



## Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн сургалтад тавигдах шаардлага

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн сургалт нь ажил мэргэжлийн онцлог, чиг үүрэг, мэргэжил, боловсролын байдалд тохирсон агуулга, бүтэцтэй байна.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн сургалтын агуулга нь зорилтот бүлгийнхэнд чиглэгдсэн байна.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг зохион байгуулах үндсэн байгууллага нь Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв байх бөгөөд Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн сургалтын албаар батлагдсан сургалтын хөтөлбөр, агуултын дагуу эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад сургалтыг зохион байгуулна.

### Хоёр. Сургалтын хэлбэр

2.1. ЭМБХХМ-ийн сургалтыг зохион байгуулахад орчин үеийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, тухайлбал, интерактив онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, төгсөлтийн дараах тасралтгүй сургалтанд ашиглаж болно.

### Гурав. Сургалтын агуулга

#### 3.1. Сургагч багшид тавигдах шаардлага

3.1.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн сургагч багш нь нийгмийн эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухаан, байгаль орчин, эрүүл ахуй болон холбогдох чиглэлээр бакалавраас дээш боловсролтой, сурган заах арга зүйн сургалт болон үндэсний сургагч багшийн сургалтанд хамрагдсан байна.

3.1.2. Сургагч багш нь үндэсний хэмжээнд Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажилтнууд, Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагчид, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламжийн ажилчид, хог хаягдлыг тээвэрлэх жолооч, ачигч нарт сургалт явуулна.

3.2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажилтнуудад тавигдах шаардлага

3.2.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажилтнууд нь тухайн эмнэлэгт эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын асуудлыг хариуцаж ажиллах бөгөөд төгсөлтийн дараахь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр зохион байгуулагдаж буй зохих түвшний эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтанд хамрагдсан байна.

3.2.2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн мэргэжилтэн нь зохих сургалтанд хамрагдсан байх шаардлагатай.

3.2.3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажилтан нь эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн ажилтан бэлтгэх сургалтанд хамрагдсан байх шаардлагатай.

3.2.4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, хяналтын тогтолцоо, аюулгүй ажиллагааны талаар сургагдсан байна.

### 3.3. Эрүүл мэндийн ажилтнуудад тавигдах шаардлага


3.3.1. Эрүүл мэндийн ажилтнууд нь эрхэлж буй ажил, мэргэжлийн онцлогтой холбоотой хог хаягдлын ангилах, ялгах, цуглуулах, түр хадгалах, эрүүл мэндийн эрсдэл, аюулгүй ажиллагааны талаарх байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд хамрагдана.

3.3.2. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд нь Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр 2 жил тутамд сургалтанд заавал хамрагдана.

### 3.4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх байгууллагын ажилчдад тавигдах шаардлага

3.4.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх жолооч болон ачигч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх талаар сургагдсан байх шаардлагатай.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 12-ны өдрийн  
A/505 дугаар тушаалтын 8 дугаар хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг бүртгэх,  
тээвэрлэх, устгасан тухай бүртгэлийн маягт**

1. Эрүүл мэндийн байгууллагад үүсч байгаа аюултай хог хаягдлыг өдөр бүртгэнэ.
2. Аюултай хог хаягдлын мэдээг нэгтгэн харьяа аймаг дүүргийн Эрүүл мэндийн газарт сар бүрийн 5-ны дотор хүргүүлнэ.
3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын мэдээг нэгтгэж, ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны албандаа сар бүрийн 10-ны дотор цахимаар хүргүүлнэ.
4. ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны алба нь мэдээнд дүн шинжилгээ хийж ЭМЯ-нд жил бүр тайлагнана.

**Хүснэгт 1.** Эрүүл мэндийн байгууллагад аюултай хог хаягдлыг бүртгэх маяг

Тасаг, нэгжийн нэд

**Жич:** Тасаг, нэгжүүд аюултай хог хаягдлыг өдөр бүр бүртгэж, тухайн байгууллагын тархвар судлаач нэгийн симас, нийтслэлийн эрүүл мэндийн газарт сар бүр хургуулна.

Хүчинт 2. Эрүүл мэндийн байгууллагын албаныг хамгаалж МАЯТ

**Байгүүллагын нэр**..... Тээврийн хэрэгслийн дугаар ..... Жолбоочийн Нэр, улс.....

**Хүснэгт 3. Аюултай хог хаягдлыг боловсруулах, устах байгууламжид хүлээлгэн өгөх буртгэлийн маягт**

.....ОН.....sar.....өдөр

Тээврийн хэрэгслийн дугаар.....Жолоочийн нэр, утас.....

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Халдвартай хог хаягдал /кг/	Хурц узүүртэй, иртэй хог хаягдал /кг/	Эмгэг хог хаягдал /кг/	Эмийн болон эсэд хортой хог хаягдал /кг/	Химийн хог хаягдал /кг,л/	Цацраг идэвхт хог хаягдал	Хүлээн авсан хүний гарын үсэг

Жич: Энэхүү хүснэгтийг аюултай хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагын тээврийн хэрэгслийн жолооч хог хаягдлыг боловсруулах байгууламжид хүлээлгэн өгөхдөө хөтөлнө.

**Хүснэгт 4. Халдвартай хог хаягдлыг уураар халдвартайжүүлэх буртгэлийн маягт**

Эрүүл мэндийн байгууллагын нэр

.....ОН.....sar.....өдөр

Цикл	Халдвартай хог хаягдлын хэмжээ	Автоклавт халдвартайжүүлж эхэлсэн цаг, минут	Автоклавт халдвартайжүүлж дууссан цаг, минут	Ашигласан горим	Ажилтны овог нэр	Холбоо барих утасны дугаар	Гарын үсэг
1							
2							
3							

**Хүснэгт 5.** Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тайлангийн маягт

*Аймаг, хот  
Байгууллагын*

..... OH ..... cap

ЦААРГАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛ	Химийн хог хаягдап /кг,л/	Эмгэг хог хаягдап /кг/	Хурц узүүртэй, иргэй хог хаягдап /кг/	Халдвартай хог хаягдап /кг/	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР
					Сумын эрүүл мэндийн төв
					Өрхийн эрүүл мэндийн төв
					Хувийн хэвшлийн эмнэлэг
					Аймгийн нэгдсэн эмнэлэг
					БОЭТ
					Дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлэг
					Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
					НИЙТ ДУН

Жич. аймаг, нийспэлийн эрүүл мэндийн газрын хог хаягдалийн асуудал хариуцсан мэргэжилтэн Хүснэгт 1-ийн бөглөсөн мэдээллийг нэгтгэн, ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт, судалгааны албанад сар бүр хургуулна.

## **Хүчинт 6. Зөвнүүн хол хаягдлыг хүлээн явьж**

Хүлээн авсан байгууллага

Хүлээндэгэн өгсөн байгууллага

ОГНЮ

ХАГДЛЫН ХҮЧЛҮҮЛГЭН ЕГСӨН ХУНИЙ АЛБАН ТУШААЛ

Han

卷三 文獻

ХІБІСКА СОЛНЦЕВІДАНИ! ДУГААН

ХУЛЮУ УАРИХ УГАСНЫ АУЦАН

XAH! ALI XAH!

АЖИЛТНЫ НЭ

ХЧНЭТ 7. ХИМНИН ХОГ ХАРЛАГДУУЛУҮСҮҮЛЭХ МАГТ

Хүлээн авсан байгууллага

ХҮЧИЙН АРСАН ГААНЫ УЛЛАГА

Ortho

**Хаягдлыг хүлээндэг нийтийн албан тушаагдлыг**

Han

卷之三

арын үсэг

Холбоо барих утасны дүгээр

ХАЯГДАЛ ХҮЛЭЭН НЭСЧИЙ ТЭЭВРЛГЭЭН МАЛЖИАЛЫГ

АЖИЛДЫҢ

卷三

**Хүснэгт 8. Нэр хаяг тодорхойгүй, холимог бодисыг хупээспэх маягт**

**Хүлээн авсан байгууллага**

Огноо \_\_\_\_\_

№	Холилдсон бодисын нэр	Хэрэглээний зориулалт	Төлөв байдал	Хэмжих нэгж /ш, мЛ, кг/	Тоо хэмжээ	Савлагдсан байдал

Хаягдлыг хупээлгэн өгсөн хүний албан тушаал  
 Нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_  
 Гарын үсэг \_\_\_\_\_  
 Холбоо барих утасны дугаар \_\_\_\_\_  
 Хаягдал хупээн авч тээвэрлэсэн машини дугаар \_\_\_\_\_  
 Ажилтны нэр \_\_\_\_\_  
 Гарын үсэг \_\_\_\_\_

